

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2023-04-29

Хурал хийсэн газар: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж, Холидэй инн Улаанбаатар зочид буудлын 2 давхарт байрлах хурал-уулзалтын танхимд хуралдав.

Эхэлсэн цаг: 13:00

Дууссан цаг: 15:40

Хурлыг зарласан: Монос Хүнс ХК

Хурлын зохион байгуулагч бүрэлдэхүүн:

Хурлын дарга: ТУЗ-ийн дарга Х.Ананд

Хурал зохион байгуулах комиссын дарга: Үйл ажиллагаа хариуцсан захирал П.Тодрол

Тооллогын комиссын дарга: Санхүүгийн менежер Э.Амарболд

Тоологын комиссын гишүүд: Санхүүгийн шинжээч П.Энхбаяр

Бүтээгдэхүүний менежер Ц.Дөлгөөнмайдар

Тэмдэглэл хөтлөсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах,
2. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах,
3. Компанийн 2022 оны үйл ажиллагаан, санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцүүлэх,
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг хэлэлцүүлэх,
5. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцүүлэх,

Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга Х.Ананд хурлыг нээж, 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 02/03 дугаартай “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай” тогтоолыг уншиж хурал хуралдах өдөр, цаг байршил, хурлын зарыг түгээсэн сувгуудыг мэдээлж, тооллогын комиссын бүрэлдэхүүнийг уншиж танилцуулаад Тооллогын комиссын дарга Э.Амарболдыг индэрт урив.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд: Нийт хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Үүдэнд бүртгэлийн хэсэгт нилээн ачаалалтай байна. Бүртгэл үргэлжилсээр байна, одоогоор бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг тасалбар болгоод ирцийн тогтоолоо танилцуулья.

Тооллогын комиссын тогтоол №01 уншиж танилцуулав. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2, 67.3.8, 68.4 дахь хэсгийг тус тус үндэслэн Компанийн саналын эрх бүхий энгийн нийт 408,850,428 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 344,008,058 ширхэг хувьцаа буюу 84,14%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд бүртгүүлж, зайнаас холбогдсон буюу танхимд өөрийн биеэр хүрэлцэн ирж оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлын үйл ажиллагааг эхлүүлэв.

Хурлын дарга хурлын дэгийг танилцуулав. Дэгийн дагуу:

1. Монос хүнс ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах, тайланг Гүйцэтгэх захирал А.Отгондарь
2. Монос хүнс ХК-ийн 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах, тайланг БДО аудит ХХК-ийн партнер Л.Баярцогзол
3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг танилцуулах, дүгнэлтийг хурлын дарга Х.Ананд,
4. Ногдол ашиг тараах тогтоолыг танилцуулах, ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны гишүүн Ц.Цэцэгбадам,

5. ТУЗ-ийн 2023 оны төсвийн санал танилцуулах, ТУЗ-ийн хараат бус гишүүн, ЦУНДХ-ы дарга Б.Гантулга,
6. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг танилцуулах, гүйцэтгэх захирал А.Отгондарь,
7. Асуулт хариулт
8. Хэлэлцэх асуудлаар цахимаар санал өгөх зааврыг танилцуулах,
9. Санал хураалтын дүнг танилцуулах, Тооллогын комиссын дарга Э.Амарболд,
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолыг танилцуулах, хурлыг хаах, Хурлын дарга Х.Ананд

Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал А.Отгондарь “Монос Хүнс” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав. Тайланг тэмдэглэлд хавсаргав. Танилцуулгад: “Монос Хүнс” ХК-ийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, одоо үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүний танилцуулга, шинээр нэмж хөгжүүлсэн бүтээгдэхүүн, хүний нөөцийн мэдээлэл, 2022 онд тохиолдсон онцлох үйл явдлууд, санхүүгийн голлох үзүүлэлтүүд, хувьцааны ханшийн мэдээлэл, маркетингийн үйл ажиллагаа, экспортын үйл ажиллагаа, шинээр төлөвлөж буй МФС үйлдвэр 2.0 төсөл, одоо хэрэгжүүлж буй стандарт, 2023 оны үйл ажиллагааны зорилго, зорилт зэргийг танилцуулав.

Хэлэлцэх асуудал 1: Хурлын дэгийн дагуу БДО аудит ХХК-ийн төлөөлөн Л.Баярцогзол “Монос Хүнс” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компани БДО аудит ХХК-аас гаргасан дүгнэлтийг танилцуулав. Дүгнэлтийг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулгад: БДО аудит ХХК-ийн болон Монос хүнс ХК-ийн санхүүгийн тайланд хяналт хийсэн гэрээт ажлын баг бүрэлдэхүүний товч мэдээлэл, санхүү тайлангийн аудитын зорилго, НББ-ийн бодлогын сонголт, тооцоолол, аудитын дүгнэлтийн товч агуулга, аудитын гол асуудлууд, зөвлөмж хүргүүлсэн илрүүлэлтийн талаар мэдээлж танилцуулав.

Хэлэлцэх асуудал 2: Хурлын дэгийн дагуу хурлын дарга Х.Ананд “Монос Хүнс” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаад Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг танилцуулав. Дүгнэлтийг тэмдэглэлд хавсаргав.

Хэлэлцэх асуудал 3: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны гишүүн Ц.Цэцэгбадам 2023 оны 02 дугаар сарын 08 өдрийн 30/02 тоот “Ногдол ашиг хуваарилах тухай” Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг эх хувиар нь уншиж танилцуулав. Тогтоолыг тэмдэглэлд хавсаргав.

Тогтоолд: Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 30% буюу 981,241,027 төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 2.4 төгрөгийн ногдол ашгийг холбогдогдох татварыг суутган “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохоор тусгасан болохыг танилцуулав.

Хэлэлцүүлэх асуудал 4: ЦУНДХ-ы дарга Б.Гантулга хурал давхцсан ирж амжаагүй тул 2022 оны ТУЗ-ийн зардлын гүйцэтгэлийг болон 2023 оны ТУЗ-ийн төсвийг ҮАХЗ П.Тодрол танилцуулав. 2022 оны ТУЗ-ийн төсөв 89,5 сая төгрөг төсөвлөснөөс 75,4 сая төгрөгийн зарцуулалт гарч, төсөвлөсөн зардлын 84% зарцуулсан талаар, мөн 2023 онд ТУЗ ХЭЭХ-д 30 сая, ТУЗ хурал, явцын зардалд 8 сая, ТУЗ цалинд 71.2 сая, нийт 109.2 сая төгрөг төсөвлөөд байгааг танилцуулав.

Хэлэлцэх асуудал 5: Хурлын дэгийн дагуу Гүйцэтгэх захирал А.Отгондарь “Монос хүнс” ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг танилцуулав. Дүрэмд оруулж байгаа нэмэлт өөрчлөлтийг тэмдэглэлд хавсаргав.

Цахимаар санал хураах зааврыг дэлгэц дээр танилцуулав.

Хурлын дарга Х.Ананд: Өнөөдрийн хурлаар хэлэлцүүлэх асуудлууд дуусч байна. Хурлын дэгийн дагуу асуулт хариултын цаг эхлэж байна. Хуралд оролцож байгаа та бүхэн заалнаас мөн цахимаар асуултаа чөлөөтэй асууж болно.

Асуулт 1: Хувьцаа эзэмшигч Ихбаяр: Сайн байцгаана уу, бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Монос хүнс компанийн дотоодын зах зээлийн тэлэлт сайн явагдаж байна, миний эргэн тойронд байгаа хэрэглэгчдийн тоо ч өсч байна, энэ нь борлуулалт, цэвэр ашгийн хувиас харагдаж байна. Цаашид компани олон улсын зах зээл, экспорт руу чиглэсэн ямар төлөвлөгөөтэй байна бэ?

Хариулт: ТУЗ-ийн дарга Х.Ананд: Манай бүтээгдэхүүний онцлог бол инноваци дээр тулгуурласан дотоодын ургамлыг холимогжуулан гаргаж авсан бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд гарган гэсэн зорилго байдаг. Компани нэмж хувьцаа гаргасан зорилго ч хамтдаа гадагшаа гарья гэсэн зорилго байсан, танилцуулгын явцад гүйцэтгэх захирлын ярьснаар бид хөрш 2 том улс руу гаргахаар төлөвлөж байгаа, мөн дундад ази Киргизстан улс руу гаргахаар салбараа байгуулсан. Киргизстан улс 6 сая гаруй хүн амтай энэ улс руу бид гаргахаар гэрээ хэлцлээ хийж байна. Мөн Хятад, Орос улс руу гаргаж байна.

Асуулт 2:Хувьцаа эзэмшигч Жавхлан: Сайн байцгаана уу, би бол насанд хүрээгүй хүүхэд Энхрийлэнгийн хууль ёсны төлөөлөгч учир хуралд оролцож байна. Монос хүнс үндэсний тэргүүлэгч үйлдвэрлэгч компани гэдэг нь харагдаж байна. Аливаа байгууллагын угтах үйлдлээс удирдлага хүртлэх харилцаанаас байгууллагын дүр төрх харагддаг. Энэ олон ажилтандаа компани ажилтны соёл болон эдийн засгийн дэмжсэн санхүүгийн боловсролыг сайн олговол Моносын хэмжээний ажилтнуудын хувьцааны худалдан авалт нэмэгдсэнээр хувьцааны ханш өсөхөд нөлөөлнө гэж бодож байна. Компани одоо шинэ үйлдвэр барьж байгаа юм байна. Энэ хөрөнгийг бүртгэлдээ бүртгэж авах нь хувьцаа эзэмшигч бидний хөрөнгө улам нэмэгдэж, үнэ цэнэ өсөхөд нөлөөлнө гэж харж байна. Та бүхэн энэ талаар ямар саналтай байна бэ?

Хариулт: ТУЗ гишүүн, гүйцэтгэх захирал А.Отгондарь: МУ-ын хэмжээнд хүний нөөцийн асуудал маш хэцүү сэдэв болоод байгаа, хувьцаа эзэмшигчийн төлөөлөл энэ асуудал руу анхаарч байгаад маш баяртай байна. Энэ нь гүйцэтгэх засаглалын ганц анхаарах сэдэв биш. Монос хүнс компани одоо 260 ажилтантай, энэ ажилтнуудын 78% нь хувьцаа эзэмшигч болсон, олон брокер компанид данстай, компанийн зүгээс тогтвортой ажиллах хүчний олон төрлийн арга хэмжээ авч байгаа, таны хэлсэн ажлуудыг хийж эхлээд байна. Монос групп компаниудын хэмжээнд нийт 1000 гаруй хувьцаа эзэмшигч байна. Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг маш олон жил хараат бус байдлаар авч байна, судалгааны дараа компанийн ажилтнуудын сэтгэл ханамжийг сайжруулах үүднээс олон арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

Асуулт 3:Хувьцаа эзэмшигч Сэргэлэнбаатар: Сайн байцгаана уу, байгаль орчиндоо ээлтэй үйлдвэрлэл явуулж байна уу? Бусад компаниас юугаараа ялгаатай бэ? Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлээ хэрхэн өргөжүүлэх бэ?

Хариулт: ТУЗ гишүүн, гүйцэтгэх захирал А.Отгондарь: Танилцуулгын явцад байгаль орчны үнэлгээг та бүхэнд танилцуулсан. Цаашид энэ үнэлгээг сайжруулах болно. Одоогийн үйлдвэрлэлийн тухайд гэвэл “Энхжин” цайн дээр гэхэд жилд 8 тонн хог хаягдлыг бууруулж үйлдвэрлэж байгаа нь том өөрчлөлт жижиг зүйлээс эхэлдэгийн нотолгоо юм. Цаашид MFC 2.0 төсөл дээр үүнийг том өөрчлөлтөөр харуулахаа хариуцлагатайгаар мэдэгдэж байна. Шинэ үйлдвэр дээр хуванцарын хэрэглээг 30%, цахилгаан эрчим хүчний хэрэглээг 20-30% тус тус бууруулна, саарал усаа илүү үр ашигтай хэрэглэнэ. Дулааны асуудлаа зэргэлдээ үйлдвэрийн илүүдэл дулаанаас авч шийдвэрлэх зэргээр байгаль орчиндоо ээлтэй байх талд бусдыгаа түүчээлэх компанийн 1 болно.

Асуулт 4:Хувьцаа эзэмшигч “Таванбогд капитал ҮЦК” ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Г.Мөнх-Эрдэнэ: Сайн байцгаана уу, манай хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултыг асууя. Танай компани намар одоогийн үйлдвэрээс 2-3 дахин хүчин чадалтай үйлдвэр барьж байгаа гэж мэдээлж байсан. Одоо үйлдвэрийн гүйцэтгэл ямар байгаа, үр дүн ямар байдлаар цаашид гарах бэ? Ашиг орлогод яаж нөлөөлөх бэ? гэдэгт одоо хүртэл нэгдсэн мэдээлэл байхгүй байгаа, үүнд боломжит хэмжээнд хариулт өгнө үү?

Хариулт: Хурлын дарга Х.Ананд: Манайх яагаад үйлдвэр барих болсон бэ гэхээр компани “Экос” усаар жишээлэхэд орон даяар байгаа борлуулалтын цэгүүдэд бүрэн хүрч чадахгүй байгаа, энэ зах зээлийг бид хангах хүчин чадал хэрэгтэй байна. Нөгөө талаар Моно хүнс компани анх IPO хийж байхад олон нэр төрлийн бүтээгдэхүүн шинээр гаргахаар амлаж байсан, тэр бүрийг хийх хүчин чадалтай үйлдвэр бидэнд хэрэгтэй байгаа учир төслийг эхлүүлсэн. Үйлдвэрийн явцын танилцуулгыг ГЗ А.Отгондарь хийнэ.

Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Барилга бүрэн битүүрч, дотоод заслын ажил явагдаж байна. Явцын гүйцэтгэл 80% -тай байна. Тоног төхөөрөмжийн хувьд халуун хүйтэн савалгааны шугам тоног төхөөрөмж тээвэрлэгдээд ирчихсэн байна. Одоо тоног төхөөрөмжийг суурилуулах ба үүнийг гадаадын

инженерийг урьж хийлгэнэ. Бүтээгдэхүүн хөгжүүлэлт маш их хугацаа шаарддаг бөгөөд энэ ажил 2018, 2019 оноос эхэлсэн учир технологийн хувьд бүх судалгаа шинжилгээ дүгнэлтээ дуусгаад тест туршилт хийх зэрэг ажлууд шууд эхэлнэ. Олон хүндрэл нөлөөлсөн ч барилгын төлөвлөлт хугацаандаа байгаа.

Асуулт 5:Хувьцаа эзэмшигч Мөнхбүрэн: Ноднин хурлын үеэр хүүхэд бүрт 500 ширхэг хувьцаа олгогдоно гэж байсан, тэр олгогдох уу? 2. Ноднин нэгж хувьцаанд 2 төгрөг өгсөн энэ жил 4 мөнгө нэмж өгч байна. Ногдол ашиг яагаад өсдөггүй юм бэ? ТУМ өнгөрсөн жил 8, энэ жил 15 төгрөг болж өссөн.

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Өнгөрсөн жил Шангрилад хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийсэн. Тэр арга хэмжээг зохион байгуулсан тал нь “Мандал инвестмент” компани байсан тэдний зүгээс тараасан хувьцаа учир тэр компаниас асуусан нь зөв байх. Манайх тэр хувьцаа тараахад оролцоогүй. Ногдол ашгийн тухайд компани MFC 2.0 төсөл гээд сая та бүхэнд танилцууллаа, бид үйлдвэрийн барилгаа 6000 м.кв талбайтай болгон өргөтгөж байгаа, үүнийг бид 22 тэрбум төгрөгийн санхүүжилтээр барьж байна. Энэ нь компанийн санхүү дээр ачаалал болно. Үйлдвэр 7 сарын сүүлээс ашиглалтанд орж, тест үйлдвэрлэлээ хийгээд, бүтээгдэхүүнээ гаргаад зах зээлд байршуултал 2023 онд ашгаа өгөх үү гэхээр бас үгүй, компани анх IPO хийхдээ ногдол ашгийн бодлогодоо 30% өгч байхаар тусгасны дагуу бид ногдол ашгаа өгөөд явж байна. Хөрөнгө оруулалтын шийдвэрийг хувьцаа эзэмшигч та бүхэн бас уялдуулж бодож ойлгох хэрэгтэй. ТУЗ-ийн хурлаар энэ асуудлыг маш нухацтай олон удаа авч хэлэлцсэн. Үйлдвэр ашиглалтанд орохоор цаашид хувьцааны үнэ цэнийн өсөлтөд нөлөөлөх болно.

Асуулт 6:Хувьцаа эзэмшигч Өнөрбат: 1.Танай компани улирал бүр тайлангаа танилцуулж, хувьцаа эзэмшигч бидэнд санхүүгийн тайлан мэдээллээ нээлттэй өгч байдаг баярлалаа. Цаашид хувьцаа эзэмшигчдийн фэйсбүүк группт тайлангаа байнга тавьж, уламжлалаа үргэлжлүүлж байгаарай гэж хүсье. 2. 4-р улирлын тайланг харахад ашиг буурсан байсан, энэ нь хүйтний улирал эхэлсэн учир буурсан гэж ойлголоо. 3. MFC төсөл маань хэзээ ашиглалтанд ороод хэзээнээс бүрэн хүчин чадлаараа ажиллах бэ? Проспектүс дээр 10 тэрбумын ашигтай ажиллана гэж байсан, энэ дүнд сая яригдсан экспортын борлуулалтын дүн орсон уу? Зөвхөн монголын зах зээлээс олох борлуулалтын дүн үү? Сая асуулт асуусан хүнд зөвлөхөд хувьцаа авна гэдэг банканд мөнгөө хадгалуулчихсан юм шиг хүү тооцож байгаа юм шиг ногдол ашиг асуугаад байх шаардлагагүй, хувьцааны ханш өсөх нь хувьцаа эзэмшигчдэд илүү үнэ цэнэтэй байдаг. Хэрэв ногдол ашиг харж хувьцаа авч байгаа бол “Таван толгой”, “АПУ” гэсэн өндөр ногдол ашиг тараадаг компани байгаа, тэднийг сонгож авсан нь дээрээ. MFC бол өсөлттэй зах зээл буюу цаашид ирээдүйтэй зах зээлээ тэлэх хувьцаа учир миний хувьд бол ногдол ашиг чухал биш, компани зах зээлээ тэлээд орлого, ашиг нь нэмэгдээд 10, 20 тэрбумын ашигтай ажиллаж байвал энэ компанийн хувьцааны үнэ өсөх учир хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийн дүн чухал биш гэж хувьцааны зах зээл дээр ажиллаж байгаагийн хувьд зөвлөгөө өгмөөр байна.

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Компани тайлагнал ил тод байдлыг хангах үүрэгтэй учир үүргээ биелүүлээд ажиллаж байна. Засаглалын хувьд хараат бус 3 гишүүн ТУЗ-ийн дэргэдэх хороодыг даргалдаг, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хараат бус гишүүд хуралдаа маш идэвхтэй оролцдог. Аудитын хороо гэхэд сар бүр хуралддаг, ТУЗ гүйцэтгэх засаглалыг дэмжээд оролцоо ихтэй ажилладаг, тайлан мэдээг хувьцаа эзэмшигчдэд тавих шаардлагыг тавьж ажилладаг. Бид проспектүс дээр 10 тэрбумын ашигтай ажиллана гэж тусгасан ч энэ нь ковид зэрэг шалтгааны улмаас биелүүлэх боломжгүй байгаа талаар би хувьцаа эзэмшигчдийн хурал дээр та бүхэнд тайлагнаад явж байгаа. Бид проспектүс дээр тусгаснаас 1 жил орчмоор хоцорч явж байгаа, нөгөө талаар ковидоос шалтгаалж манай улсын иргэд хийжүүлсэн ундаа, чихэрлэг зүйлсээс татгалзаж эрүүл хүнсийг сонгох, усны хэрэглээ нэмэгдсэн тоо гарч байна. Тиймээс бид MFC төслийг хэрэгжүүлэх саналаа ТУЗ руу олон удаа танилцуулж шийдвэр гаргуулсан. Бид 2026 оны тооцоолол дээр 10 тэрбумын ашигтай ажиллахаар тооцоолсон байгаа.

Асуулт 7:Хувьцаа эзэмшигч: Хувьцаа эзэмшигчдэд хөнгөлөлтийн карт олгож болох уу? Бүтээгдэхүүнээ би өөрөө худалдаж авахад ийм карт олгож өгч болох уу?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Шууд хариулах боломжгүй байна. Цаашид бодож үзье.

Хурлын дарга Х.Ананд: За асуулт хариултын цаг дууссан байна. Санал хураалтын цаг эхэлсэн. Та бүхэн дэлгэцнээс цахимаар хандаж санал өгөх заавартай танилцаад саналаа өгнө үү. /Санал хураалт 20 минут үргэлжлэв/



Хурлын дарга Х.Ананд: Санал хураалтын дүнг танилцуулна уу гээд тооллогын комиссын дарга Э.Амарболдыг урья.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд: Саналаа идэвхтэй өгсөн хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа. Тооллогын комиссын зүгээс санал хураалтын дүнг танилцуулья.

Батлах асуудал 1: “Монос Хүнс” ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай” санал хураалтын дүн:

1. Зөвшөөрсөн – 343,354,677 ширхэг буюу 99.996 % ;
2. Татгалзсан - байхгүй ;
3. Түдгэлзсэн – 14,882 ширхэг буюу 0.004% ;
4. Санал өгөөгүй/хүчингүй- байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Батлах асуудал 2: “Монос хүнс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийг батлах” санал хураалтын дүн:

1. Зөвшөөрсөн – 343,358,017 ширхэг буюу 99,997 % ;
2. Татгалзсан – 480 ширхэг буюу 0,000 % ;
3. Түдгэлзсэн – 11,101 ширхэг буюу 0,003% ;
4. Санал өгөөгүй/хүчингүй хуудас байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Батлах асуудал 3: “Монос хүнс ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах” санал хураалтын дүн:

1. Зөвшөөрсөн – 343,069,726 ширхэг буюу 99,996 % ;
2. Татгалзсан – байхгүй ;
3. Түдгэлзсэн – 14,805 ширхэг буюу 0,004% ;
4. Санал өгөөгүй/хүчингүй хуудас байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хурлын дарга Х.Ананд: Санал хураалтын дүнд үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах 01, 02, 03 дугаарт тогтоолыг уншиж танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, хамт олон, хурлыг зохион байгуулах комисс, тооллогын комисс зэрэг Монос хүнс компанитай холбоотойгоор өнөөдөр хүрэлцэн ирсэн бүх хүмүүст баярлалаа гэснээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа 15 цаг 45 минутанд дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.Цагаанхүү

Н.ЦАГААНХҮҮ

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА



Х.АНАНД